

АККРЕДИТАЦИ, СЕРТИФИКАТЧИЛАЛЫН ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭН ДЭХ ЗОХИЦУУЛАЛТ

А.Ичинхорлоо*

Монгол улс нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин, хувийн салбар эдийн засгийн 80 орчим хувийг бүрдүүлэх болсон өнөө үед олон улсын эмжээнд нийцсэн чанар, стандартын тогтолцооны ач холбогдол нэмэгдсээр байна. Олон улсын хэмжээнд улс орнууд нь янз бүрийн аккредитаци ба сертификатчилалын систем, практикийг¹ зайлшгүй болон сайн дурын үндсэн дээр² хэрэгжүүлдэг бөгөөд ялангуяа хөгжиж байгаа орнуудын харилцан адилгүй систем, чанарын баталгаа нь тэдний гадаад худалдаанд, тухайлбал, өндөр хөгжилтэй орны зах зээлд гарах боломжийг хааж байдаг байна. Монгол улс нь ДХБ болон Олон улсын стандартын байгууллагын (ОУСБ) гишүүн болсоноор чанар, стандартын тогтолцоог сайжруулах, мэдээлэл солилцох, тэдгээр байгууллагаас мэргэжлийн тусламж авах ач холбогдолтой болсон. Гэхдээ цаашид зөвхөн бараа бүтээгдэхүүний бус, мөн үйлдвэрлэлийн арга ажиллагаа, менежмент болон байгаль орчны менежментийн олон улсын стандартыг³ нэвтрүүлэх, гадаадаас орж ирж байгаа компанид тавих стандартын хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах шаардлага байсаар байгаа билээ.

Олон улсын хэмжээнд энэ асуудлыг анх 1975 оны 5 сард ГАТТ-ын Хелсинкийн бага хурлаар авч хэлэлцсэн бөгөөд үүнээс хойш олон улсын зохицуулалтын нэг асуудал болсон. Өнөөдөр аккредитаци ба сертификатчилалын салбарт Олон улсын Стандартын байгууллага-ОУСБ (ISO), Олон улсын цахилгаан техникийн хороо (IEC) болон Дэлхийн худалдааны байгууллага (WTO), олон улсын аккредитацийн бага хурал (ILAC) зэрэг байгууллагууд голлох үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ILAC-ийн хүрээнд

* МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

¹ W.Werner, *Handbuch Akkreditierung und Zertifizierung*, Weinheim, New York, 2000, 6 тал

² J.Ensthaler, *Zertifizierung, Akkreditierung und Normung fuer den EU-Binnenmarkt*, Berlin 1995

³ W.Masing, *Handbuch Qualitätsmanagement*, 4 хэвлэл, Munchen, 1999, 29 тал

үндэсний төлөөлөгчид чуулж, олон улсын хэмжээн дэх үндсэн зарчмуудыг тогтоодог, энэ нь олон улсын стандартын байгууллагын гол баримтлах зарчим болдог.

1. Худалдааны техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (ТВТ)-т тусгагдсан байдал

Уг хэлэлцээрээр олон улсын худалдааг хөнгөвчлөх үүднээс оролцогч орнууд нь чанар, стандартын хэм хэмжээ, системийг олон улсын хэмжээнд нийцүүлэх үүргийг хүлээдэг. Худалдааны техникийн саад тотгорт юуны өмнө техникийн заавар журам, хэм хэмжээ, үүнд сав баглаа боодол, тэмдэглэгээний шаардлагууд, техникийн заавар, хэм хэмжээний хяналт шалгалтын процесс мөн хамаарна. Гэхдээ ТВТ-аар үйлчилгээ, төрийн хангамж, эрүүл ахуйн арга хэмжээг хамардаггүй байна. Аккредитаци ба сертификацлалын хүрээнд доорх зарчмуудыг ТВТ-д тусгасан байдаг:

- чанар стандартын тохиргоонд хийх аливаа хяналт шалгалт нь агуулга, тавьсан нормын хувьд ойлгомжтой, ил тод байх ёстой. Иймээс гишүүн орнууд энэ талаар мэдээллийн төвтэй байна.
- Гишүүн орнууд нь аль болохуйц Олон улсын байгууллагуудаас (ISO, IEC гэх мэт) гарч байгаа олон улсын хэм хэмжээг (норм) өөрийн стандарчлалд авч хэрэглэх.
- Аккредитаци болон сертификацийн үйл ажиллагааг янз бүрийн байгууллагаар зохицуулах, өөрөөр хэлбэл, засгийн газар, орон нутгийн байгууллага болон төрийн бус байгууллагыг өргөнөөр хамруулах.
- ДХБ-ын зохицуулалтад нийцэхгүй аливаа олон талт системийг бий болгохгүй байх.

ТВТ-ийн салшгүй нэг хэсэг бол аливаа нормыг бий болгох, хүлээн зөвшөөрөх, хэрэглэхдээ баримтлах зөв үйл ажиллагааны кодекс бөгөөд энэ нь гишүүн орны стандарт, хэм хэмжээний байгууллагууд заавал биелүүлэх үйл ажиллагааны хэм хэмжээг зааж өгдөг.

Ингэж ДХБ нь стандарт хэмжил зүй, аккредитаци, сертификатчилалын асуудалд Олон улсын стандартын байгууллагатай хамтран ажилладаг.

2. Европын холбооны хүрэн дэх аккредитаци ба сертификатчилалын асуудал

Европын Холбооны комиссоос хувийн болон улсын байгууллагын үйл, ажиллагааны зардлыг ихээхэн бууруулах зорилгоор доорхи зорилгыг тавьсан:

- гишүүн орнууд хяналт шалгалт, гэрчилгээ олголт болон сертификатчилалыг харилцан хүлээн зөвшөөрөх;
- гишүүн аль нэг орны үйлдвэрлэгчид тавих давхар хяналтыг арилгах замаар зах зээлд орох боломжоор хангах.

Үүний тулд харилцан нэгэн ижил аккредитаци болон сертификатчилалын системд шилжих зорилт тавьсан бөгөөд “Хяналт шалгалт ба сертификатчилалын глобал концепт”-ийг боловсруулан мөрдөж байна.

Нөгөө талаар Европын Холбооноос бусад 3-дагч өндөр хөгжилт орнуудтай бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хяналт, сертификатчилалыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр байгуулсан байдаг⁴. OECD-ийн судалгаагаар ЕХ, АНУ болон Япон зэрэг аж үйлдвэржсэн орнууд харилцан хүлээн зөвшөөрснөөр доорхи үр дүнд хүрсэн гэж үздэг:

- o харилцан хүлээн зөвшөөрөх явцад тэдгээрийн чанар, стандартын ялгаа мэдэгдэхүйц багассан, бүтээгдэхүүний дизайн өөрчлөх шаардлагагүй болсноор зардал багассан байна.
- o Хяналт шалгалтыг хийх үйл ажиллагаа, дамжлага багасч, үүнд зарцуулах үйлдвэрлэгчийн зардал багассан. Ингэснээр үнэ буурахад хүргэсэн. Мөн хяналтын лаборатори, сертификатын байгууллагуудын хооронд өрсөлдөөн бий болсноор үнэ буурахад хүрсэн: зарим байгууллага нь гадаадад хүлээн зөвшөөрөгдөх аккредитаци авсан. Үйлдвэрлэгчдийн хувьд энэ нь “one-stop-shop” буюу давхар сертификат авах шаардлагагүй болсон. Түүнчлэн сертификат, лабораторийн байгууллагуудыг аккредитацчилахдаа ISO-IEC болон EN 45000-нормыг мөрдөх болсон байна.

Дээрхээс харахад заавал биелүүлэх чанар стандартын тогтолцоо төдийгүй сайн дурын аккредитаци, стандартчиллын тогтолцоог олон улсын хэмжээнд харилцан уялдуулах нь хувийн болон улсын салбарт ихээхэн үр ашиг, зах зээлийн боломжийг бий болгодог.

Иймд Монгол улс нь энэ чиглэлийн олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллахдаа бодит эдийн засгийн үр дүн, олон улсын практикийг судлан, байгаль орчин, менежментийн ач холбогдлыг нэмэгдүүлэх

⁴ An assessment of the costs for international trade in meeting regulatory requirements, 1999, www.oecd.org

шаардлагатай байна. Үүний үр дүнд гадаад зах зээлд гарах болон шинэ техник технологи нэвтрэх боломж нэмэгдэх нь дамжиггүй билээ.

Ашигласан материал:

1. *ISO, Benefits of Standardization, Швейцарь, 1982.*
2. *ISO, International Trade Center, UNCTAD/GATT, Certification Principles and Practice, Швейцарь, 1980*

The article tells us about international regulation and cooperation in accreditation and certification sector. The author aims to show that for a successful transition to market economy it is important that accreditation and certification system is good organized and that intensive cooperation with industrial countries and international organizations in this sector very helpful is.